

2025/9/15

№ 25/21

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь Ард Кредит ББСБ ХК болон Ариг банк хооронд 2025 оны 2 сарын 27-ны өдөр байгуулсан №MN950021002199000785 тоот зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангах хүрээнд батлан даагчаар оролцохыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
2. Батлан даалтын гэрээний нөхцөл, эрх, үүрэг, хариуцлагыг энэ тогтоолын Хавсралт 1-д заасан нөхцөлөөр **БАТАЛСУГАЙ.**
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Ариг банктай батлагааны гэрээ байгуулах, үүнтэй холбоотой баримт бичигт гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Золбоод **ОЛГОСУГАЙ.**

ДАРГА



Ч.ГАНХУЯГ